



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/141

Шивээговь сум

“Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх” ажлыг хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16.5.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх” ажлыг хүлээж авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

Б.Дэлгэрдалай
(ГХБХБГ-ын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Л.Бадамханд
(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

С.Энхцэцэг
(1 дүгээр багийн иргэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Алтансүх
(Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй “Нийтийн эзэмшлийн байр болон гэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, шинэчлэх” ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг комиссын дарга (Д.Отгонжаргал)-д, өмч хөрөнгийг бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, эдийн засаг төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Б.Алтансүх)-д, өмч хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, үр ашгийг дээшлүүлэн ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг байгууллагын дарга (Д.Отгонжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА